ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ
/2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР/

2022.06.10 Улаанбаатар хот

| № | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | | Хэрэгжилтийн явц | Хэрэгжилт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая.төг) | Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | | |
| **Зорилго** 3.7.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | | |
| 1. | 3.7.7.“Шинэ Зуунмод”, “Майдар” шинэ хотуудын хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлнэ. | 2.“Шинэ Зуунмод” хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2020 2024 | Улсын төсөв | 11,085.5 | Хот байгуулах тухай УИХ-ын 2020 оны 55 дугаар тогтоол гарсан. Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээг хийж, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулсан. | Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө , инженерийн дэд бүтцийн зураг төслийг боловсруулна | 3,227.7 | - | Барилга, хот байгуулалтын яамнаас "Шинэ Зуунмод" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, "Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 143 дугаар тогтоолоор батлагдсан. "Шинэ Зуунмод" хот нь Засаг захиргааны нэгжийн харьяаллын хувьд Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт оршдог тул тус асуудлыг Барилга, хот байгуулалтын яам хариуцан ажиллаж байна. | 100 |
| 2. | | 3. “Майдар” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий | 2021 2024 | Улсын төсөв | 8,767.9 | Хот байгуулах тухай УИХ-ын 2020 оны 55 дугаар тогтоол гарсан. | Хотын хөгжлийн төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий | 1,528.1 | - | - Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их хуралд өргөн барихаар ажиллаж байна. Тус | - |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | төлөвлөгөөг батлуулж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | | | | | төлөвлөгөөг боловсруулсан байна. | | | хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд Майдар хотыг соёл боловсрол, аялал жуулчлалын чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэхээр тусгагдсан.<br>- “Майдар хот” төслийн байршил нь Засаг захиргааны нэгжийн харьяаллын хувьд Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт оршдог тул тус асуудлыг Барилга, хот байгуулалтын яам хариуцан ажиллаж байна. | |
| 3. | 3.7.12. Хот, суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 1.Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын далан, сувгийн өндөржилтийн нэгдсэн зураг төсөл боловсруулна. | 2020 2021 | Улсын төсөв | 300.0 | Улаанбаатар хотын гадаргуугийн болон гүний усны түвшний өндөржилтийн нэгдсэн зураг төсөл байхгүй. | Улаанбаатар хотын баруун болон суурьшлын шинэ бүсийн үерийн хамгаалалтын далан сувгийн өндөржилтийн нэгдсэн зураг төслийг боловсруулж батлуулсан. | - | - | 2021 онд Сонгинохайрхан, Баянгол, Хан-Уул дүүргийн өндөржилтийн нэгдсэн зураг төслийг “Инженер геодези” ХХК хийж гүйцэтгэсэн. 2022 оны 1 дүгээр улиралд магадлалын дүгнэлт хийгдсэн. | 100 |
| 4. | | 2.Улаанбаатар хотын гадаргуугийн ба газар доорх үерийн хамгаалалтын барилга байгууламж төлөвлөх арга аргачлал, загварчлал хийх, инженерийн бэлтгэл арга хэмжээний | 2021 2022 | Улсын төсөв | 1,200.0 | Улаанбаатар хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө байхгүй. Судалгааны ажил хийгдсэн. | Улаанбаатар хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна. | 900.0 | - | Улаанбаатар хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөний эхний тайланг Мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 10 хурлаар, дундын тайланг Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 19 хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Захиалагчийн хяналтыг Барилга, хот байгуулалтын яам тавьж байна. | 70 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мастер төлөвлөгөө боловсруулан батлуулна. | | | | | | | | | |
| Зорилго: 5.1.Ногоон хөгжил. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | | | | | | |
| 5. | 5.1.1. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь хүртэл бууруулж, бусад томоохон хот, суурин газрын агаарын бохирдлын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ. | 4.Улаанбаатар хотын инженерийн шугам сүлжээг шинэчлэх, шинээр барих арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2020 2024 | Орон нутгийн төсөв, бусад эх үүсвэр | 100.000.0 | Ус, дулаан, цахилгаан холбоо, дохиоллын шугам сүлжээний зураг төслийг боловсруулж, барилгын ажлыг эхлүүлнэ. | Барилгын ажлыг үе шаттай гүйцэтгэнэ. | 20,000.0 | - | - Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар Эрчим хүчний сайдын хөрөнгө оруулалтын багцад батлагдсан Гэр хороолол болон шинэ суурьшлын бүсийн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчинд холбох, эрчим хүчээр хангах, хүчдэлийн уналтыг сайжруулах, цахилгаанаар халаах боломжийг бүрдүүлэх, дэд станц, шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх ажлын зургийг зөвшилцөж баталгаажуулсан.<br>- АНУ-ын Мянганы сорилын сангийн буцалтгүй тусламжаар хийгдэх доод эх үүсвэрийн ус хангамжийн төслийн барилга байгууламж, шугам сүлжээний нарийвчилсан зураг төслийн ажлыг АНУ-ын АЭКОМ ХХК, үндэсний зөвлөх “Престиж инженеринг” ХХК хамтран гүйцэтгэж байна. Төслийн барилга угсралтын ажлыг хоёр багцад хуваан хэрэгжүүлэх ажлын зургийг хянаж баталгаажуулах ажил хийгдсэн. Барилга угсралтын ажлын гүйцэтгэгч шалгаруулах ажил хийгдэж байна. Монголын Мянганы сорилын сан Захиалагчийн хяналт тавин ажиллаж байна. | 70 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | - Цэвэршүүлсэн усыг үйлдвэрлэлд ашиглах чиглэлээр ус дамжуулах шугам хоолой, ДЦС-3, 4-ийн модификацын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг ХБНГУ-ын Фихтнер Ватер энд Транспортейшн компани, Монгол Улсаас “Икон” ХХК гүйцэтгэж байна. Төв цэвэрлэх байгууламжаас гарсан усыг дахин цэвэршүүлж дулаан цахилгаан станцуудын технологийн усны хэрэглээнд ашиглах ф1000 мм ийн голч бүхий технологийн усны трасс, насос станцын байршлын судалгаа хийгдсэн. | |
| Зорилго: 6.1.Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ. | | | | | | | | | | | |
| 6. | 6.1.1. Улаанбаатар хотын хөгжлийн төлөвлөгөөг “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичгийг үндэслэн 20 жилээр төлөвлөнө. | 1. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ. | 2021<br>2024 | Нийслэл төсөв | 1,235.8 | Хот байгуулалтын суурь судалгаа үнэлгээний ажил хийгдсэн. 2040 оны концепц боловсруулагдсан | Хот байгуулалтын үндсэн суурь баримт бичигтэй болно. | 338.2 | 0 | Барилга, хот байгуулалтын Сайдын 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г хэлэлцүүлэн дэмжиж, Монгол Улсын Засгийн газарт өргөн барьж хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Тус шийдвэртэй холбогдуулан дараах материалын бүрдлийг хангуулан Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Үүнд:<br>✓ УИХ-ын тогтоолын төсөл,<br>✓ УИХ-ын тогтоолын төслийн танилцуулга,<br>✓ УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлал,<br>✓ Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага | 70 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | урьдчилсан тандан судалгааны тайлан;<br>✓ Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн судалгааны тайлан;<br>✓ Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлан;<br>"Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай" Монгол Улсын Их хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Барилга, хот байгуулалтын сайд, Хууль зүй, дотоод хэргийн Сайдаар батлуулсан бөгөөд одоогоор Засгийн газрын яамдаас Улсын Их Хурлын тогтоолын төсөлд санал авахаар ажиллаж байна. | |
| 7. | 6.1.3 Хотыг дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, гэр хорооллын газрыг шинэчлэн | 2. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг шинэчлэн төлөвлөн барилгажуулах төслийг хэрэгжүүлнэ. | 2021 2025 | Улсын төсөв, Нийслэлийн төсөв | 12,000.0 | 1556 өрхийн 13 орон сууц ашиглалтад орсон. | 600 айлын орон сууц | 4,000.0 | - | - Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх 1-48, 2-48, 4-48, 3-20 дугаар байр, Баянзүрх дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх ХАА-27 дугаар байр, Сүхбаатар дүүргийн 10 дугаар хороо хорооны нутаг дэвсгэр дэх 1, 2, 3, 4, 6, 9, 10 дугаар байр зэрэг Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 1175 өрхийн орон сууцны барилгыг буулган дахин төлөвлөн барилгажуулах, орон сууцыг орон сууцаар солих замаар чөлөөлөх, чөлөөлсөн талбайд түрээсийн орон сууцны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, | 70 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулж, ногоон орон сууц, шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ. | | | | 28,000.0 | | | 10,860.5 | | зохион байгуулан ажиллахыг “Нийслэлийн Орон сууцны корпораци” ХК-д шилжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/498 дугаар захирамжаар батлуулсан.<br>- Баянзүрх дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэр, төсөл хэрэгжүүлэгч “Металл энд Вүүд” ХХК нь ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны Төмөр замын 5 дугаар байр 12 айлын орон сууцыг буулгаж, 137 айлын үйлчилгээтэй орон сууцны барилга, Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэр, төсөл хэрэгжүүлэгч “Эм Эм Жи Капитал” ХХК нь ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны Нэхмэлийн 3 дугаар байр болох 27 айлын орон сууцыг буулгаж, 97 айлын үйлчилгээтэй орон сууц, нийт 234 айл өрхийн орон сууц ашиглалтад орсон.<br>- Төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах 31 багцын 70 барилгын сонгон шалгаруулалтыг 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн хооронд олон нийтэд нээлттэй зарлаж, 6 багцын 14 барилгад, 5 аж ахуй нэгж төсөл хэрэгжүүлэх санал ирүүлсэн бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/264 дүгээр захирамжаар байгуулагдсан Үнэлгээний хорооны хуралд | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. | |
| 8. | | 5.Улаанбаатар хотын гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах ажлын хүрээнд гэр хорооллын газрын дахин төлөвлөлтийн зураг төслийг боловсруулж, төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2020 2024 | Гадаадын зээл тусламж төр хувийн хэвшил | 10,000.0 | Холбогдох 2 журам батлагдсан. Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах загвар төслийн 3 байршлыг сонгож холбогдох судалгаа төлөвлөлт хийгдсэн. | Зураг төслийн ажлын даалгаврыг боловсруулах загвар зургийг хянан баталгаажуул сан байна. | 3,000.0 | | Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд 3 байршилд барилгажилтын төсөл баталсан. Үүнд:<br>✓ БЗД, 13, 14 дүгээр хороо Г хэсэгчилсэн талбайд "Бүрд констракшн" ХХК<br>✓ БЗД, 13, 14 дүгээр хороо Ё хэсэгчилсэн талбайд "Ай энд Жи" ХХК<br>✓ СБД, Орон сууцны 7 дугаар хорооллын Г, Й хэсэгчилсэн талбай "Бэрэн девелопмент" ХХК | 90 |

5 зорилтын 8 арга хэмжээний хэрэгжилтийн хувь – 71.2%

ХЯНАСАН:ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ч.БАДАМХАНД

НЭГТГЭСЭН: АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Л.ЭНХТУУЛ